

Co-funded by  
the European Union



switchasia



CZECH REPUBLIC  
DEVELOPMENT COOPERATION

AFD



# СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ БҮЛЭГТ  
КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ХӨЛ ХОРИОНЫ  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ШУУРХАЙ ҮНЭЛГЭЭ



*Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын хэрэгцээнд зориулав*



МОНГОЛЫН  
БООГАМЖ  
ҮНДЭСНЭГ  
АЖААЛГА



Улаанбаатар, 2020 он

## АГУУЛГА

---

ТАЛАРХАЛ .....	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	4
НЭГ. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ .....	5
ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН .....	5
ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	18



МИРИМ Консалтант ХХК-ийн судалгааны баг нь Европын Холбооны санхүүжилтээр ЖЭРЭС ОУТББ, ПИН ОУТББ, МБҮА, БЭХХТ нар хамтран “Улаанбаатар хотын төлөвлөгдөөгүй бүсэд тогтвортой эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барихад зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх төслийн” захиалгаар “Дулаан шийдэл” төслийн зорилтот КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорионы үзүүлэх нөлөөллийн шуурхай үнэлгээг хийв.

Энэхүү судалгааны ажлыг хэрэгжүүлэхэд “Дулаан шийдэл” төслийн хамт олны туслалцаа маш их байсан бөгөөд тэр дундаа судалгааны ажлын явцад үнэтэй зөвлөгөө, удирдамж, мэдээллээр хангасан ПИН ОУТББ төслийн мэргэжилтэн М.Тамирт болон судалгаанд идэвхтэй оролцож, төслийн өнөөгийн нөхцөл байдал, КОВИД 19 цар тахлын хөл хорионы үзүүлж буй нөлөөллийн талаар ярилцсан Монголын барилгын үндэсний ассоциацийн менежер Г. Эрдэнэчимэг, ЖЭРЭС ОУТББ төслийн санхүүгийн зохицуулагч Т. Уламбаяр, Барилгын эрчим хүчний хэмнэлтийн төвийн захирал Б. Мөнхбаяр, Барилгын бригадын төлөөлөл Д. Мөнхнасан, Э. Оюубиндэрьяа болон зорилтот 150 өрхийн төлөөлж судалгаанд идэвхтэй оролцсонд та бүхэнд талархал илэрхийлье.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

---

ААН	Аж ахуй нэгж
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АХБ	Азийн хөгжлийн банк
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БЭХХТ	Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ГХАОЗТ	Гэр хорооллын амьдрах орчны зураглалын төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МАН	Монгол ардын нам
МБУА	Монголын барилгын үндэсний ассоциаци
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ОУТББ	Олон улсын төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
УОК	Улсын онцгой комисс
УИХ	Улсын их хурал
ТББ	Төрийн бус байгууллага
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
ПИН	Пипл Ин Нийд
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

## ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

---

Зураг 1. Та Ковид-19 цар тахлын шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдэх эсэх, %.....	9
Зураг 2. Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалан хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн эсэх, %.....	10
Зураг 3. Өрхийн гол орлого олдог хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн салбар, %.....	11
Зураг 4. Танай өрхийн орлогыг хүрэлцээ Ковид-19-н нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдсөн эсэх, %.....	12
Зураг 5. Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орсон эсэх, %.....	13
Зураг 6. Байр орон сууцны хувьд цаашид ямар төлөвлөгөөтэй байгаа, %.....	14
Зураг 7. Орон сууцны дулаан алдагдлаа бууруулахад нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, %.....	15
Зураг 8. Орон сууцны дулаалга, засвар үйлчилгээгээ хэнээр хийлгэх вэ, %.....	15
Зураг 9. Ковид 19-н хөл хорио үргэлжилбэл танай завсар хийх дулаалах төлөвлөгөө хэрэгжихгүй байх эрсдэл байгаа эсэх, %.....	15
Зураг 10. Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөний өөрчлөлт болон Ковидоос хамаарах эрсдэлийн үнэлгээний харьцуулалт, %.....	17
Хүснэгт 1. Байр орон сууц худалдан авах төлөвлөгөө болон хугацаа, %.....	14
Хүснэгт 2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааны үнэлгээ (1 бол муу, 5 бол сайн).....	<b>Error! Bookmark not defined.</b>

## Нэг. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ

---

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь “Дулаан шийдэл” төслийн үйл ажиллагаанд Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы үзүүлэх нөлөө, эрсдэлийг тодорхойлоход чиглэнэ. Энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлээ. Үүнд:

1. 2019 оны эхээр төслийн суурь судалгаанд хамрагдсан зорилтот хорооны өрхийн амьжиргаа, эдийн засагт Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы үзүүлэх нөлөөллийг тодорхойлох,
2. Ковид-19 цар тахлын үеийн хөл хорио өрхийн эдийн засгийн албан бус салбарын орлогод үзүүлэх нөлөөллийг тодорхойлох,
3. Төслийн суурь судалгаанд хамрагдсан зорилтот хороодын өрхүүдийн нийгэм, эдийн засагт Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы үед үзүүлэх нөлөөлөл өрхүүдийн богино хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох,
4. Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы үед өрхүүд орон сууц дулаалгын үйлчилгээ авах тохиолдолд үүсэх эрсдэлийг тодорхойлох
5. Төслийн хэрэгжилтэд учирч байгаа гол асуудлууд

Судалгаа нь (i) баримт бичгийн тойм судалгаа болон хэрэглэгдэхүүн боловсруулах; (ii) зорилтот хороодын өрхүүдээс асуулга болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөллөөс ярилцлага судалгааны мэдээлэл цуглуулах (iii) Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлан боловсруулах гэсэн үе шатуудаас бүрдсэн. Судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан цуглуулсан.

**Баримт бичгийн судалгааны** хүрээнд дараах 3 төрлийн баримт бичгүүдийг судалсан.Үүнд:

- Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы үзүүлэх нөлөөллийн талаар хийгдсэн судалгаанууд,
- Гэр хороололд агаарын бохирдол болон орон сууцны дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл
- 2020 оны улс төрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт агаарын бохирдол болон орон сууцны дулаан алдагдлыг бууруулах чиглэлд тусгасан зүйл заалтуудыг судалсан.

**Иргэдийн асуумж судалгаа:** 2019 оны эхээр төслийн суурь судалгааг 416 өрхийн дунд зохион байгуулсан ба эдгээр өрхүүдээс орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөтэй байсан 150 өрхөөс утсаар мэдээл цуглуулсан. Судалгааны асуумжийг урьдчилан бэлтгэж захиалагч талаар батлуулахын зэрэгцээ судалгааны мэдээлэл цуглуулалт эхлэхээс өмнө туршилт судалгааг зохион байгуулсан. (Иргэдийн судалгааны анхдагч үр дүнг энэхүү тайлангийн хавсралт 1-ээс үзнэ үү)

## ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

---

МУЗГ-аас 2020 оны 1-р сарын 26-ны өдрийн 30-р тогтоолоор “шинэ коронавирусын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх”, “бэлэн байдлыг хангах” зорилгоор 6-р сарын 30 хүртэл “өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгтэй хөл хорио тогтоосон. Одоогоор (2020.07.02 байдлаар) УОК-оос хөл хориог 2020.07.15 хүртэл сунгах шийдвэр гаргаад байна.

Өнөөдрийг хүртэл Монголд 220 Ковидын халдварын тохиолдол бүртгэгдсэн ч бүгд гаднаас зөөвөрлөгдөж ирсэн, тусгаарлалтад эмчлэгдээд гарч байгаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгтэй хөл хорио тавьж бүх шатны сургууль, цэцэрлэг болон сургалтын үйл ажиллагааг зогсоох, хилийн хорио тавих, хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, үндэсний хэмжээний баяруудыг тэмдэглэхгүй байх, үйлчилгээний газруудыг хаах болон ажиллах цагийг богиносгох, олон нийтийг хамарсан аливаа үйл ажиллагааг хориглох зэрэг томоохон арга хэмжээнүүдийг тухай бүрт хэрэгжүүллээ. Манай улсад одоогийн байдлаар зөвхөн зөөвөрлөгдөж ирсэн тохиолдлууд (no community transfer) бүртгэгдэж байгаа нь уг халдварт өвчний дэгдэлт болон тархалтыг хязгаарлах, түүний эрсдэлийг бууруулах зорилгоор хийгдсэн дээрх шийдвэрүүд үр дүнтэйг харуулж болох хэдий ч дотоодын ААН-үүдийн үйл ажиллагаа, цаашлаад Монголын бизнесийн салбарт том хэмжээний гадаад орчны цохилт болон орж байгаа ба үүнээс хамаарсан иргэдийн амьдралд үзүүлэх нийгэм, эдийн засгийн нөлөөлөл улам нэмэгдсээр байна.

АХБ-ны 4-р сард гаргасан тайланд дурдсанаар цар тахлын тархалтыг хязгаарлах зорилгоор тавьсан хөл хорионы арга хэмжээнүүд нь дотоод болон гадаад зах зээлийн эрэлт нийлүүлтэд цочрол үүсгэж эдийн засгийг хурдацтай сааруулж байна. Мөн 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Хөгжиж буй Азийн улс орнуудын эдийн засгийн өсөлт өмнөх оны 5.2 хувиасаа 2.2 хувь хүртлээ бууж удаашрах ба Монгол улсын хувьд 2.1 хувийн өсөлттэй, 2021 онд 4.6 хувь байх таамаглалыг гаргажээ. АХБ-н тайланд дурдсанаар инфляцын дундаж түвшин 2019 онд 7.3% бол өссөн бол 2020 онд эдийн засгийн идэвхжил үлэмж суларч өсөлт огцом саарахтай уялдан 6.6% болж буурна хэмээн төсөөлжээ<sup>1</sup>.

Монгол улсын ҮСХ-ны 1-р улирлын тайланд дурдсанаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар буурсан, өмнөх сараас 6.1 хувиар буурсан байна. Харин МҮХАҮТ<sup>2</sup>-н 3-р сарын сүүлд 1504 аж ахуйн нэгжийг хамруулан авсан судалгаагаар судалгаанд оролцогчдын 56% нь ажлын цагийн зохицуулалт хийсэн, 33% нь ажиллагсдаа түр болон бүр мөсөн чөлөөлсөн байна. МҮХАҮТ-н судалгаанд хамрагдсан ААНБ-уудын хувьд эдийн засгийн хүндрэл энэ хэвээр үргэлжилбэл судалгаанд оролцогчдын 30% нь нийт 8,000 тооны ажлын байрыг цомхотгох төлөвлөгөөтэй гэжээ. Засгийн газраас эдийн засгаа эрчимжүүлэх, бизнесүүдээ дэмжих арга хэмжээ авахгүй тохиолдолд 200-250 мянган хүн ажлын байраа алдах эрсдэлтэй байна. ҮСХ-ны 1-р улирлын тайланд дурдсанаар ажилгүйдлийн даатгалын сангаас эхний улирлын байдлаар 5.3 мянган хүнд 12.9 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 3.9 тэрбум төгрөгөөр буюу 43 хувиар нэмэгдсэн дүн юм<sup>3</sup>.

Монгол банкны 2020 оны эхний улирлын тайлан мэдээлэлд дурдсанаар Ковид-19-ийн дэгдэлтээс үүдэн хөл хорио тогтоосноос эдийн засаг удааширч, улмаар иргэд, аж ахуйн нэгжүүд зээлийн болон түрээсийн төлбөрөө зогсоох, царцаах, гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах хүсэлт шаардлага тавьж байна<sup>4</sup>.

ҮСХ-ын мэдээлэлд дурдсанаар аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 3.0 их наяд болж, өмнөх оны мөн үеэс 35 хувиар буурсан байна. Ковид-19 халдварын үеэр хөл хорио тавьсантай холбоотойгоор хүмүүсийн хүнс ахуйн бараа хэрэгслээ нөөцлөх хандлага бий болж байгаа. Түүний дагуу

<sup>1</sup> Азийн хөгжлийн банк, [www.adb.org](http://www.adb.org)

<sup>2</sup> Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, [www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)

<sup>3</sup> Үндэсний статистикийн хороо, [www.nso.mn](http://www.nso.mn)

<sup>4</sup> Монгол банк, [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

Монголын жижиглэн худалдааны борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 1,7 хувиар, бөөний худалдааны борлуулалтын орлого 6.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Харин ачаа тээврийн салбарын хувьд Ковид-19 эдийн засгийн хямралын хохирлыг хамгийн ихээр амсаад буй салбаруудын нэг юм. Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 10,2 сая тонн ачаа ачсан нь өмнөх оны мөн үеэс 33,4 хувь буурсан үзүүлэлт юм. Бүх төрлийн тээврээр зорчсон зорчигчдын тоо ч мөн ижил хэмжээгээр, 31,4 хувиар буурсан байна. Ийнхүү салбарын нийт орлого өмнөх үеийнхээс 25 хувиар, өмнөх улирлаас 37 хувиар унаад буй. Харин төмөр замын тээврийн орлого өссөн нь уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт нэмэгдсэнтэй холбоотой юм. Аялал жуулчлал цар тахлын тархалтыг хязгаарлах зорилготой арга хэмжээ, албадан хаалт, олон улсууд хилээ хааж нислэг хүлээж авахгүйгээ мэдэгдсэн зэрэгтэй холбоотойгоор хамгийн их хохирлыг амсаж байгаа салбар болоод байна.

Сант марал сангаас 2020 оны 5-р сард 1200 хүнийг хамруулсан үндэсний хэмжээний судалгаагаар коронавирус нь ажил эрхлэлтэд маш их нөлөөлсөн гэж 48.8 хувь нь, тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэж 34.7 хувь нь үзсэн байна. Үүнд дундаас доогуур буюу **эмзэг бүлэгт** хамаарагдах өрхийн хувьд маш их нөлөөлсөн гэсэн хариулт нь дундаж, дундаас дээгүүр бүлгээс 10 хувиар илүү байна. Өрхийн орлого санхүүгийн байдалд маш их нөлөөлсөн гэж 42,8 хувь нь, тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэж 36,7 хувь нь үзсэн байна<sup>5</sup>. Үүнд дундаас доогуур буюу **эмзэг бүлэгт** хамаарагдах өрхийн хувьд маш их нөлөөлсөн гэсэн хариулт нь дундаж бүлгээсээ 14 хувиар, дундаас дээгүүр бүлгээс 21,3 хувиар өндөр байна. Товчоор хэлбэл эмзэг бүлгийн өрхийн ажил эрхлэлт, санхүү нь маш муудсан байна.

Тус судалгаанд оролцсон хүмүүсийн 20,3 хувь нь коронавирусын улмаас ажлаа алдсан гэж хариулжээ. Ажлаа алдсан хүмүүс **хүйсийн** хувьд адил байна. Эмзэг бүлэг нь бусад бүлгээсээ илүүтэй ажлаа алджээ.

“Нээлттэй нийгэм” форумгаас 2020 оны 04 сарын дундуур Ковид-19 цар тахал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн нөлөө үзүүлж байгаа судалгааг явуулсан ба энэ судалгаанд өрхийн орлого хэвийн байгаа боловч байнга гэртээ суух гишүүдийн тоо нэмэгдсэнээр өрхийн гишүүдийн хүнс болон ахуйн хэрэглээ өссөн ба зэрэгцээд бараа, материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор өрхийн орлогын хүрэлцээ буурсан байна. Өрхийн орлого нэмэгдээгүй боловч зардал өсөж байгаа энэ үед “... сардаа гардаг зардлаа нэмэгдүүлэхгүйн тулд хэмнэлт хийж” байгаа ажээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд Ковид-19 цар тахлын үед тулгамдаж байгаа хамгийн чухал асуудал бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд тэгш хамруулах асуудал хөндөгдсөн байна.

Зорилтот айл өрхүүдээс авсан судалгаа

Судалгаа авсан 150 өрхийн 66 хувь нь Сонгинохайрхан дүүргээс, 34 хувь нь 34 хувь нь Сүхбаатар дүүргээс оролцсон. Оролцогсодын нас, хүйсний харьцааг доор графикаас үзнэ үү?


<sup>5</sup> Sant Maral Foundation, [https://830a862d-3fe6-40e6-b731-5a65590fd0cf.filesusr.com/ugd/915e91\\_93af0bbe81514b22a542fa4f42a89ea7.pdf](https://830a862d-3fe6-40e6-b731-5a65590fd0cf.filesusr.com/ugd/915e91_93af0bbe81514b22a542fa4f42a89ea7.pdf)

<sup>6</sup> Open Society forum [https://www.forum.mn/index.php?sel=project&menu\\_id=561&f=one&obj\\_id=5791](https://www.forum.mn/index.php?sel=project&menu_id=561&f=one&obj_id=5791)



Асуултад хариулагсдын 59.3% хувь нь өрхийн тэргүүн, 28.7% нь эхнэр нь, 9.3% нь хүүхэд нь, 0.7% ач хүү/ охин нь, 1.3% эцэг эх нь, 0.7% ах дүү нь байлаа. Өрхийн гишүүдийн тооны хувьд 18% нь 1-2, 59.9% нь 3-5, 22% 6 ба түүнээс дээш гишүүнтэй байв.

**График 1. Насны ангилал, %**




**График 2. Хүйсийн харьцаа, %**



**График 3. Судалгаанд оролцсон өрхийн гишүүн, %**




**График 4. Өрхийн гишүүдийн тоо, %**



Судалгаанд оролцсон айл өрхийн 56.7% хувь нь ам бүлээрээ (эхнэр, нөхөр, хүүхэд), 19.3% нийлмэл (эхнэр, нөхөр, хүүхэд, эмээ, өвөө, хамаатан), 14.7% эмэгтэй тэргүүлэгчтэй өрх (эх, хүүхэд), 4.7% эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (эцэг, хүүхэд), 4.7% ганц бие өрх байжээ.


2019 оны Үндэсний статистикийн газрын мэдээгээр өрхийн дундаж орлого 1 381 000₮ байсан бол Улаанбаатар хотын хэмжээнд өрхийн дундаж орлого 1 583 412₮ байлаа. Гэвч манай судалгаанд оролцсон айл өрхийн 94% хувь нь улсын дунджаас доогуур орлоготой өрхүүд юм.



**График 5. 2019 оны байдлаар өрхийн орлогын түвшин %**


Судалгаанд оролцсон 150 өрх оролцсон ба эдгээр өрхүүдийн 145 өрх (96,7%) нь Ковид-19 цар тахлын шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замын мэднэ гэсэн бол 3,3% мэдэхгүй гэсэн хариултыг өгч байна. Ковид-19 цар тахлын шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдлэгтэй эсэхийг оролцогчдын хүйс, насаар харьцуулан үзэхэд ялгаа байхгүй байна.

**Зураг 6. Та Ковид-19 цар тахлын шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдэх эсэх, %**



Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтаалан хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн эсэхийг тодруулахад 21.3% өөрчлөгдсөн гэсэн бол 78% хүүхдийн зан ааш өөрчлөгдөөгүй гэсэн хариултыг өгсөн байна. Хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн эсэхийг өрхийн орлогын өөрчлөлттэй харьцуулахад энэ хоёр үзүүлэлт хоорондоо хамааралтай байна. Тухайлбал хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн гэсэн хариулт өгсөн оролцогчдын 37.5%-н өрхийн орлого өөрчлөгдөөгүй гэсэн бол, 62.5% өрхийн орлогод өөрчлөлт орсон байна. Сургууль цэцэрлэг хаагдаж зурагтаар хичээл зааж байгаа ч хүүхэд уйдаах, уцаартай болох, элдэв юм нэхэх зэрэг зан аашийн өөрчлөлт гарч байжээ.

Зураг 7. Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалан хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн эсэх, %



Төслийн зорилтот өрхийн суурь өвчтэй хэн нэгэн Ковид-19 хөл хорионоос болж эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдсан тохиолдол байгаа эсэхийг тодруулахад өрхийн **6.7%** тийм буюу хязгаарлагдсан гэсэн бол, **93.3%** нь үгүй буюу ямар нэг хязгаарлалтад өртөөгүй байна. Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдсан шалтгааныг тодруулахад дараах хариултыг өгч байна Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй группд байдаг хүнийг улсын эмнэлэг хүлээн авахаас татгалзсан ба одоо тэр бээр хувийн эмнэлэгт үзүүлж байна гэсэн **1 тохиолдол** байна
- Эмнэлгийн орны хүрэлцээ болон дараалал, хүнд суртлаас хамааран үйлчилгээ авч чадахгүй байгаа **1 тохиолдол** байна
- Эмнэлэгт хэвтэж байсан хүүхдийн хагалгаа болон эмчилгээ хойшилсон **1 тохиолдол** байна.
- Эмнэлгийн байгууллагад ороход төвөгтэй (амны хаалт зүүх, халуун үзэх, оочирлохгүй байх, олноор цуглуулахгүй байх) болсон гэсэн **7 тохиолдол** буюу нийт судалгааны явцад эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдсан **10 тохиолдол** байна.

Өрхийн гол орлогыг бүрдүүлэгч гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн салбараар авч үзвэл Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионд хамгийн их өртөж байгаа салбарууд болох үйлчилгээний салбарт 32%, худалдааны салбар 7.3%, тээврийн салбарт 6.7%, аялал жуулчлалын салбарт 2.7% ажиллаж байна.

**Зураг 8. Өрхийн гол орлого олдог хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн салбар, %**




Ковид 19 цар тахлын үеийн хөл хорионоос үүдэлтэйгээр өрхийн голлох орлого олдог хүмүүсийн ажил болон бизнест өөрчлөлт орж байгаа эсэхийг тодруулахад 52% нь хэвийн, 48% нь өөрчлөлт орсон гэсэн хариултыг өгсөн. Судалгааны явцад ажлын байранд нь өөрчлөлт орсон 48% буюу 72 оролцогчийн хувьд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Худалдан авалт буурсан-22.2%
- Ажлын цаг хэвийн боловч цалин буурсан 18.1%
- Ажлын цаг нь багасаж цалин буурсан-15.3%
- Ажлын байр хаагдсан (бар, сургууль, цэцэрлэг) болон түр цалингүй чөлөө олгогдсон-8.4%
- Ажлаас халагдсан -5.6%
- Ажил олдохгүй байгаа-3.3%

Өрхийн орлогын хүрэлцээ Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос хамааран өөрчлөгдсөн эсэхийг тодруулахад 1.3% нэмэгдсэн, 56.7% нь өөрчлөгдөөгүй, **42% нь буурсан** байна. Өрхийн орлого буурсан иргэдийг ажиллаж байгаа салбараар нь харьцуулж үзэхэд орлого нь буурсан өрхүүдийн 46% үйлчилгээ, 11.1% барилга, 11.1% худалдаа, 7.9% тээврийн салбарт ажиллаж байна.

**Зураг 9. Танай өрхийн орлогыгг хүрэлцээ Ковид-19-н нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдчөн эсэх,%**



Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос хамааран өрхийн амьдралын нөхцөл байдал муудсан тохиолдолд өрхүүд дараах арга хэмжээг авч байна. Үүнд:


- Өрхийн зардлаа багасгах, хэмнэх- 65.3%
- Зарж борлуулах боломжтой зүйлээ зарах-2%
- Дэлгүүр/найз нөхөд хамаатнуудаас зээлээр зохицуулж байна-9.3%
- Ломбардаас мөнгө зээлсэн-10.7%
- Банкнаас мөнгө зээлсэн-12.7% байна.

**Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдал дараах байдлаар нөлөөлсөн байна. Үүнд:**

- Барилгын бригад явуулдаг бизнесийн сургалтын үйл ажиллагаа доголдсон байна. Барилгын бригад өвлийн улиралд сургалт хийвэл тохиромжтой байдаг боловч 2-4 сарын үед сургалт зохион байгуулах боломжгүй нөхцөл үүссэн байна. Сургалтын үйл ажиллагааг 5 сараас эхлэн зохион байгуулж эхэлсэн боловч зуны улиралд бригадын ажлын ачаалал нэмэгддэг байна. Бригадын гишүүдийн техникийн боломж, технологийн мэдлэг муу байдгаас шалтгаалан онлайнаар сургалт явуулах боломж хомс байна.
- Зорилтот өрхүүдийн орлого буурсан болон хүлээлтийн байдалтай байгаатай холбоотойгоор барилгын ажил буурсан төлөв ажиглагдсан байна. Өнгөрсөн жил голлон сургалт, нөлөөллийн ажил явагдсан учраас энэ жилээс барилгын дулаалгын засвар идэвхжих байсан боловч барилгын дулаалгын захиалга нэмэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Одоогийн байдлаар төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа 13 бригад байгаа боловч барилгын салбар дахь захиалгат засвар үйлчилгээ багассан, төслийн хүрээнд ажлууд бага байгаатай холбоотойгоор бригадуудын орлого буурсан байна. Бригадуудын орлого буурсан нь дулаалгын засвар үйлчилгээ эхлэх үед туслах материал авах санхүүгийн чадамжгүй болсон байна. Одоогийн ашиглаж байгаа төлбөрийн системийн хувьд үндсэн материал нийлүүлэгч тал руу банк төлбөрийг нэг удаагийн шилжүүлэг хийдэг харин бүх ажлаа бүрэн гүйцэтгэж дууссаны дараа дараа бригад төлбөрөө авч байна. Иймээс барилгын дулаалга эхлэх шатанд туслах материал болон үйл ажиллагааны (шатахуун, машин түрээс) зардлуудаа бригад өөрөө санхүүжүүлэхэд хүндрэлтэй болж байна.
- Төслийн үйл ажиллагаа болон барилгын дулаалгын үйл явцыг иргэдэд биечлэн таниулах үйл ажиллагаа хязгаарлагдсан байна.
- Төслийн оролцогч талуудын дунд Ковидийн үед онлайн уулзалт явагдаж эхэлснээр ойлголцол багассан. Онлайнаар оролцож байгаа тохиолдолд оролцогчид идэвх багатай оролцож мэдээлэл дутуу авах тохиолдол байгаа. Гэхдээ 5 сараас эхлэн онлайн хурлын нөхцөл байдалд дасан зохицож талуудын ойлголцол нэмэгдэж байгаа.

Харин өрхүүдийн хувьд 2019 оны эхээр төслийн суурь судалгааг 416 өрхийн дунд зохион байгуулсан ба эдгээр өрхүүдээс орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөтэй байсан 150 өрхөөс мэдээлэл авсан эдгээр өрхүүдээс Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос үүдэлтэйгээр орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад өрхийн 17.3% дулаалга, засвар хийсэн бол 6.7% нь дулаалга, засвараа хийж байгаа, 73.3% одоогоор шийдээгүй байгаа бол 2.7% төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан байна.

**Зураг 10. Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орсон эсэх, %**



Судалгааны явцад оруулсан 2.7% буюу 4 өрх төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан байсан. Эдгээр 4 оролцогчийн өөрчлөлт оруулсан шалтгааныг тодруулахад 1 нь хэсэгчилж засвар хийхээр төлөвлөсөн бол 3 нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө хойшлуулсан байна. Өрхийн судалгаанд оролцогчдын 32% орон сууц худалдан авах сонирхолтой байгаа, 43.3% нь орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах”-аар төлөвлөж байгаа бол **24.7%** нь одоогоор шийдээгүй буюу хүлээлтийн байдалтай байна.

Дараах 3 шалтгааны улмаас иргэдэд нөхцөл байдал тодорхойгүй, хүлээлтийн байдалтай байна:

1. Улс төрийн намуудын бодлого, амлалтууд.

**2020 оны УИХ сонгуульд ялалт байгуулсан МАН-ын мөрийн хөтөлбөрөөс орон сууц, гэр хорооллын талаар тусгасан “Дулаан шийдэл” төслийн үйл ажиллагаатай холбоотой заалтууд:**

- 1.2.4. Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны урьдчилсан төлбөрийг бууруулах, чөлөөлөх үе шаттай арга хэмжээ авна.
- 1.2.5. Анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд 4-6 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээл олгоно.
- 1.2.6. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулж, хуримтлалын нэгдсэн сан, Үндэсний баялгийн сантай хамтарч төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150,000 өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ. Үүнд: Хүн амыг орон сууцаар хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан 80 мянган айлын орон сууц “Бага өртөгтэй орон сууц” хөтөлбөрийг санаачлан 50 мянган айлын орон сууц “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 20 мянган айлын орон сууц хангах
- 5.6.1 Олон төрлийн /орлоготой нийцсэн, амины, түрээсийн, ногоон/ инженерийн шийдэл бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 100,000 өрхийг орон сууцтай болгож, иргэдийнхээ 70-аас дээш хувийг орон сууцаар хангасан хот болно.
- 5.6.2. Улаанбаатар хотын гэр хорооллын төвийн, дундын, захын, зуслангийн бүсийн айл өрхийг төвийн болон хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбоно


**МАН Мөрийн хөтөлбөр, 2020**

2. Иргэдийн дунд хүлээлт үүсгэсэн нэг хүчин зүйл Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос үүдэлтэй зорилтот өрхүүдийн орлого буурсан ба эдийн засгийн цаашдын тодорхой бус байдал

3. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулах 2-3 төсөл хэрэгжиж байна. GIZ, Цэвэр агаар зэрэг төслүүд нь иргэд орон сууцны дулаан алдагдлаа бууруулсан тохиолдолд зардлын 30 % -ийг буцаан олгох, шинэ пассив хаус байшин барьсан тохиолдолд зардлын 20%-ийг олгоно гм татаастай төслүүд хэрэгжиж байгаатай холбоотойгоор иргэд тэдгээр төслүүдийг сонгох хандлагатай байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн дийлэнх нь одоогийн энэ байршилдаа үлдэн амьдрах хүсэлтэй байна. Тодруулбал 2020 оны байдлаар судалгаанд оролцогсдын 32% нь орон сууц руу нүүх сонирхолтой байгаа бол үлдсэн 37.3% нь хувийн сууцаа засах өргөтгөх, 4.7% нь энэ хашаандаа шинээр байшин барих, 27.7% нь одоогоор ямар нэг төлөвлөсөн зүйлгүй байна гэсэн хариултыг өгсөн байна. Орон сууц руу нүүх сонирхолтой өрхийн тоо 2019 оноос 4.1%-иар өссөн байна. 2019 оны судалгаагаар орон сууц рүү нүүнэ гэж буй өрхүүдийн төлөвлөгөөг орлоготой нь уялдуулан харахад бодит байдал дээр тийм ч олон байж чадахааргүй байсан ба энэ нөхцөл байдал дээр эдийн засгийн хямралын нөлөөг нэмж тооцвол эдгээр өрхүүдийн орон сууцанд орох магадлал улам буурч байна.

**Зураг 11. Байр орон сууцны хувьд цаашид ямар төлөвлөгөөтэй байгаа эсэх, %**



Орон сууцанд орно гэж төлөвлөсөн өрхүүдийн дийлэнх 81.8% ойрын хугацаанд буюу 2020-2023 онд багтаан орон сууц худалдан авах төлөвлөгөөтэй байна. Бусад өрхүүдийн олонх нь амьдарч буй орон сууцандаа ойрын 3 жилийн хугацаанд багтаан өөрчлөлт хийх зүйлстэй байна.

**Хүснэгт 1. Байр орон сууцны талаар төлөвлөгөө болон хугацаа, %**


№	Төлөвлөгөө	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2028	Нийт
1	Орон сууц худалдаж авна.	14.6%	14.6%	20.8%	31.2%	6.2%	10.4%		2.1%	100%
2	Энэ хашаа байшингаа зараад, өөр газар хашаа байшин худалдаж авна		50.0%					50.0%		100%
3	Энэ хашаандаа шинээр байшин барина	28.6%	14.3%	57.1%						100%
4	Энэ байшингаа засаж, өргөтгөнө	35.7%	33.9%	12.5%	16.1%	1.8%				100%
<b>Нийт</b>		<b>25.4%</b>	<b>24.6%</b>	<b>19.3%</b>	<b>21.1%</b>	<b>3.5%</b>	<b>4.4%</b>	<b>0.9%</b>	<b>0.9%</b>	

<sup>7</sup> WB, <https://projects.worldbank.org/en/projects-operations/project-detail/P167421>

<sup>8</sup> GIZ <https://www.giz.de/en/worldwide/17721.html> Figure 12. Future plans in relation to housing %

2019 оны судалгааны дүнгээс үзвэл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулахад ямар арга хэмжээ авах талаар тоон судалгааны үр дүнгээс харахад эхний ээлжинд иргэд цахилгаан халаагуур тавихыг хамгийн ихээр сонгосон байна. Хоёр дахь арга хэмжээгээр дулаалгыг, тэр дундаа цонх, хана, шалны дулаалгыг сонгосон байсан. Харин 2020 оны энэхүү судалгааны дүнгээс үзвэл 27.3% нь ханаа дулаалах, 24.7% нь дээврээ дулаалах, 22.7% нь цахилгаан халаагуур тавих гэсэн саналуудыг голлон гаргасан байна. Эдгээр орон сууцны дулаан алдагдлаа бууруулах хувилбаруудыг сонгосон байдлыг оноор харьцуулан авч үзвэл иргэдийн дулаалгын талаарх хандлагад өөрчлөлт гарсан байна. Тухайлбал 2019 онд ханаа болон дээврээ дулаалах сонголт бага байсан бол 2020 онд хувилбар тус бүр 10 гаруй хувиар өссөн байгааг үзвэл төслийн дулаалгын талаарх мэдээлэл зорилтот иргэддээ бага боловч хүрч байгааг харуулж байна.

**Зураг 13. Орон сууцны дулаан алдагдлаа бууруулахад нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, %**



Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” тохиолдолд хэнээр тухайн засвар үйлчилгээгээ хийлгэхийг тодруулахад 24.7% нь мэргэшсэн бригадаар, 50% өөрсдөө, 25.3% таньдаг хүнээрээ хийлгэнэ гэсэн хариултыг өгч байна.

**Зураг 14. Орон сууцны дулаалга, засвар үйлчилгээгээ хэнээр хийлгэх вэ, %**




Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хөл хорио үргэлжилбэл орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөө хэрэгжихгүй байх эрсдэлийг тодруулахад 19.3% нь маш их эрсдэлтэй, 16% их эрсдэлтэй, 41.3% дунд зэрэг эрсдэлтэй, 5.3% бага зэрэг эрсдэлтэй, 18% огт эрсдэл байхгүй хэмээн үзэж байна.

**Зураг 15. Ковид 19-н хөл хорио үргэлжилбэл танай завсар хийх дулаалах төлөвлөгөө хэрэгжихгүй**




**байх эрсдэл байгаа эсэх, %**



Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орсон байдлыг Ковид 19 цар тахлаас үүдэлтэй хөл хорио үргэлжилбэл энэхүү төлөвлөгөө хэрэгжихгүй байх эрсдэл бий эсэхийг тодруулахад “орон сууцаа дулаалах эсэхээ одоогоор шийдээгүй” байгаа 73.3% -н дийлэнх (83.6%) нь дунд болон дундаас дээш эрсдэлтэй хэмээн тодорхойлж байна.

**Зураг 16. Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөний өөрчлөлт болон Ковидоос хамаарах эрсдэлийн үнэлгээний харьцуулалт, %**



Төсөл хэрэгжүүлж байгаа 4 байгууллага Ковид-19 цар тахлын үеийн хөл хорио үргэлжилсэн тохиолдолд төслийг хэрэгжүүлэхэд учирч буй эрсдэлийн түвшнийг 4 буюу эрсдэлтэй хэмээн үнэлж байна.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

---

- Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос хамааран төслийн зорилтот бүлгийн **өрхийн орлого** өөрчлөгдсөн эсэхийг тодруулахад **42% нь буурсан** гэж хариулсан байна.
- Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы нөлөөлөлд хамгийн их өртөж байгаа салбарууд болох **үйлчилгээний** салбарт 32%, **худалдааны** салбарт 7.3%, **тээврийн** салбарт 6.7%, **аялал жуулчлалын** салбарт 2.7% ажиллаж байна. Өрхийн орлого буурсан иргэдийг ажиллаж байгаа салбараар нь харьцуулж үзэхэд орлого нь буурсан өрхүүдийн **46% үйлчилгээ**, 11.1% барилга, 11.1% худалдаа, 7.9% тээврийн салбарт ажилладаг байна. Зорилтот бүлгийн айл өрхийн дийлэнх нь албан бус хөдөлмөр эрхэлдэг.
- Байр, орон сууцны талаар цаашдын төлөвлөгөөг нь авч үзвэл судалгаанд оролцогчдын **32%** нь **орон сууц** руу нүүх сонирхолтой байгаа бол үлдсэн 37.3% нь хувийн сууцаа засах, өргөтгөх, 4.7% нь энэ хашаандаа шинээр байшин барих, 27.7% нь одоогоор ямар нэг төлөвлөсөн зүйлгүй байна гэсэн хариултыг өгсөн. Орон сууц руу нүүх сонирхолтой өрхийн тоо 2019 оноос **4.1%-иар** өссөн байна. 2019 оны судалгаагаар орон сууц рүү нүүнэ гэж буй өрхүүдийн төлөвлөгөөг орлоготой нь уялдуулан харахад орон сууц рүү нүүх өрхийн тоо бодит байдал дээр тийм ч олон байж чадахааргүй байсан ба энэ нөхцөл байдал дээр эдийн засгийн хямралын нөлөөг нэмж тооцвол эдгээр өрхүүдийн орон сууцанд орох магадлал **маш бага** байна.
- Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөтэй иргэдийн дунд хүлээлт үүсгэсэн дараах **3 хүчин зүйл** байна. (i) Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос үүдэлтэй зорилтот өрхийн орлого болон эдийн засгийн тодорхой бус байдал (ii) 2020 оны сонгуулийн үеийн намуудын амлалтууд (iii) хөгжлийн байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа ижил төстэй зорилготой, татаас бүхий төслүүд байна.
- Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөтэй байгаа өрхийн **24.7** хувь нь мэргэшсэн бригадаар хийлгүүлнэ гэсэн хариулсан. Эдгээр өрхийн **62.1%** нь Ковид - 19 цар тахал үргэлжлэх тохиолдолд төлөвлөгөөнд өөрчлөлт орох нөлөөллийг **дунд болон дундаас дээш** хэмээн тодорхойлж байна.
- Хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн эсэх нь өрхийн орлогын өөрчлөлттэй хамааралтай байна. Тухайлбал нийт өрхийн 21.3% нь хүүхдийн зан ааш өөрчлөгдсөн гэж хариулсан. Эдгээр өрхийн **62.5%-д нь өрхийн орлогод** өөрчлөлт орсон гэжээ. Ковид цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы хүрээнд сургууль цэцэрлэгт хаагдаж, цахим сургалттай байсан, гадуур гарах тоглох нь хязгаарлагдсан тул бухимдах, уйдаах, элдэв юм нэхэх зэргээр зан аашийн өөрчлөлт нь илэрч байв.
- Орон сууц худалдан авахаар төлөвлөж байгаа өрхүүдийн **81.8%** ойрын хугацаанд буюу **2020-2023** онд багтаах төлөвлөгөөтэй байна. Өрхүүдийн олонх нь амьдарч буй орон сууцандаа ойрын **3 жилийн** хугацаанд багтаан өөрчлөлт хийх хүсэлтэй байна.
- 2020 оны энэхүү судалгааны дүнгээс үзвэл 27.3% нь ханаа дулаалах, 24.7% нь дээврээ дулаалах, 22.7% нь цахилгаан халаагуур тавих гэсэн саналуудыг голлон гаргасан. Эдгээр орон сууцны дулаан алдагдлаа бууруулах хувилбаруудыг сонгосон байдлыг 2019 оны сонголттой харьцуулан авч үзвэл иргэдийн дулаалгын талаарх хандлагад өөрчлөлт гарсан байна. Тухайлбал 2019 онд ханаа болон дээврээ дулаалах сонголт бага байсан бол 2020 онд энэ хувилбар тус бүр **10 гаруй хувиар өссөн** байгааг үзвэл төслийн дулаалгын талаарх мэдээлэл зорилтот иргэддээ хүрч, бага боловч үр дүн гарч байгааг харуулж байна.
- Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад өрхийн 17.3% дулаалга, засвар хийсэн бол 6.7% нь дулаалга, засвараа хийж байгаа, **73.3%** одоогоор шийдээгүй байгаа бол 2.7% төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан байна. Дулаан шийдэл төслийн ирээдүйн гол хэрэглэгчид нь одоогоор шийдээгүй байгаа нь 73.3% нь хариулсан. Эдгээр өрхийн **83.6%** нь Ковид-19 цар

тахлын үеийн хөл хорионоос хамааран төлөвлөгөөнд өөрчлөлт орох нөлөөллийг **дунд болон дундаас** дээш хэмээн тодорхойлж байна. Тиймээс цар тахал удаан үргэлжлэх тусам “Дулаан шийдэл” төслийн хэрэглэгчид багасах, төлөвлөгөө нь өөрчлөгдөх эрсдэлтэй байна.

- Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионоос үүдэлтэйгээр өрхийн **орлогод нь өөрчлөлт орсон иргэдийн** хувьд орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орох эрсдэлийг 23.6% маш их эрсдэлтэй, 18.1% эрсдэлтэй, 44.4% дунд зэрэг эрсдэлтэй, 4.2% бага зэрэг эрсдэлтэй, 9.7% огт эрсдэлгүй хэмээн тодорхойлж байна.
- Өрхийн **орлого нь хэвийн байгаа иргэдийн** хувьд орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөнд өөрчлөлт орох эрсдэлийг 15.4% маш их эрсдэлтэй, 14.1% эрсдэлтэй, 38.5% дунд зэрэг эрсдэлтэй, 6.4% бага зэрэг эрсдэлтэй, 25.6% огт эрсдэлгүй хэмээн тодорхойлжээ. Өрхүүдийн хувьд орлого нь хэвийн болон өөрчлөлт орсон эсэхээс үл хамааран орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөгөө өөрчлөх эрсдэлтэй байна. Үүсээд байгаа нөхцөл байдлаас хамааран айл өрхүүд зайлшгүй хийгдэх ажлаас бусдыг хойшлуулах, цар хүрээг нь багасгах, ирээдүйн эрсдлээс хамгаалан хуримтлал үүсгэх, өдөр тутмын зардлаа танаж орлогын эх сурвалжаа нэмэх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” нь хийгдэх шаардлагатай үйл ажиллагааны жагсаалтын нэлээн сүүлд орохоор байна.
- Ковид-19-өөс шалтгаалан өрхүүд орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөгөө өөрчлөх эрсдэлийг **хүйсээр** харьцуулж үзэхэд төдийлөн ялгаа байхгүй байна.

### **Зөвлөмж:**

- Судалгаанд оролцсон айл өрхийн 42% -ийн орлого буурсан байна.
- Орон сууцаа “засах, өргөтгөх, дулаалах” төлөвлөгөөтэй байгаа өрхийн 24.7 хувь нь мэргэшсэн бригадаар хийлгүүлнэ гэсэн хариулсан.
- Судалгаанд оролцсон айл өрхийн 37.3% хувийн сууцаа засах өргөтгөх сонирхолтой.
- Ковид 19 цар тахлын улмаас үүдэлтэй эдийн засгийн тодорхойгүй байдал, өрхийн орлого буурсантай холбоотой дээрх 37.3%-ийн 73.3% нь ойрын хугацаанд засвар үйлчилгээ хийх эсэхээ шийдээгүй байна.
- Судалгаанд оролцогсодын 83.6% нь Ковид 19-ийн нөхцөл байдлаас шалтгаалан гаргасан шийдвэртээ өөрчлөлт оруулж болзошгүй. Өөрөөр хэлбэл зөвхөн 16.4% -ийн сууцандаа засвар үйлчилгээ хийх төлөвлөгөө нь хэвээр үлдэх юм.
- Төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгахын тулд ялангуяа дээр дурдсан хувийн сууцаа засах өргөтгөх сонирхолтой 37.3%-д зориулан ямар нэг хэлбэрийн урамшуулал, **татаас ашиглах** нь нэн чухал байна.
- Зорилтот өрхүүдийн дийлэнх санхүүгийн чадавхи сайнгүй байсан дээр Ковид 19-ийн нөлөөлөл нэмэгдсэн нь төслийг зах зээлийн зарчмаар эрэлт нийлүүлэлт дээр үндэслэн хэрэгжихэд ихээхэн хүндрэл учруулахаар харагдаж байна. Иймд төслийн баг өөр шийдлүүд нэмж олохыг зөвлөж байна. Жишээлбэл урамшуулал **татаас олгох санхүүжилт** олох, эрчим хүч хэмнэх илүү **хямд төсөр**, орлогод нийцсэн **шийдлүүд** санал болгох, банкны **ногоон зээлийн шалгуур**ыг илүү уян хатан болгох талаар холбогдох байгууллагуудыг лоббидох гм.
- Хэрэв Ковид 19-өөс үүдэлтэй нөхцөл байдал цаашид удаан хугацаанд үргэлжилхээр бол айл өрхүүдийг эрчим хүч хэмнэх талаар **мэдээллээр хангах, бригадуудыг чадавхижуулах** тал дээр илүү анхаарах хэрэгтэй байна.